



АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ

(ТАНИЛЦУУЛГА)

2018



ᠰᠤᠬᠤᠪᠠᠭᠠᠲᠤ ᠳᠦᠦᠷᠭᠢᠶᠢᠨ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

ОРШИЛ

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ЖУРАМ

Зам, тээврийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 232 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан **“Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журам”**-ын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн техникийн байдал, хэрэглээний стандартын үзүүлэлтийг хангуулах, автотээврийн хэрэгслээс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгийг явуулж, Автотээврийн хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь нийтийн тээврийн үйлчилгээний автотээврийн хэрэгслийг хагас жил тутам, бусад автотээврийн хэрэгслийг жилд нэг удаа тогтсон хугацаанд үзлэгт хамруулахаар заасан байдаг байна.

Харин Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайдын яамд, олон улсын байгууллагын автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгийг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр явуулдаг.

Техникийн хяналтын үзлэг явуулах

Автотээврийн хэрэгслийн өмчлөгчийн жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсаныг үндэслэн техникийн хяналтын үзлэгт оруулдаг бөгөөд үзлэгийн үед автотээврийн хэрэгслийн марк, модель, улсын дугаар, арал, бүхээг, хөдөлгүүрийн дугаар, өнгө, төрөл, зориулалт, өмчлөгчийн хаяг зэрэг бүртгэлийн үзүүлэлтийг автотээврийн хэрэгслийн гэрчилгээтэй нь нэг бүрчлэн тулгаж, зайлшгүй шаардагдах нэмэлт хэрэгслийг /галын хор, ослын зогсолтын тэмдэг, эмийн сан г.м./ шалгадаг байна.

Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг дор дурдсан стандартын шаардлагын дагуу явуулна гэж заасан байдаг. Үүнд:

- “Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага” MNS5011:2003;
- “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5012:2011;
- “Бензин хөдөлгүүртэй автомашин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS5013:2009;
- “Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS5014:2009;
- “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS4598:2011;
- “Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд” MNS4599:2003.

Ийнхүү техникийн хяналтын үзлэгээр стандарт шаардлага хангасан автотээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт тэмдэглэгээ хийж, техникийн хяналтын үзлэгийн гэрчилгээ олгогддог.

Тус хэлтсээс нийслэл, дүүргийн хэмжээнд техникийн хяналтын улсын үзлэгт хамрагдсан автотээврийн хэрэгслийн тоог сүүлийн 5 жилээр бэлтгэн, танилцуулга хэлбэрээр хэрэглэгч Та бүхэнд толилуулж байна.






ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИН

Улсын хэмжээнд 2018 онд 585363 автотээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсанаас 44988 (7.7%) нь баруун бүсэд, 54783 (9.4%) нь хангайн бүсэд, 67905 (11.6%) нь төвийн бүсэд, 15962 (2.7%) нь зүүн бүсэд, 401725 (68.6%) нь нийслэл Улаанбаатар хотод үзлэгт хамрагдсан байна.

Зураг 1. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины тоо, бүс нутгаар,

Нийслэлийн хэмжээнд 401725 автотээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсанаас 13.8 хувийг тус дүүргийн автомашин эзэлж байгаа бөгөөд энэ нь 2017 оноос 1.1 пунктээр буурч, харин 2014 оноос 0.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


Дүүргийн хэмжээнд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины тоо 2018 онд 55.5 мянга болж, өнгөрсөн оноос 1.1 (2.1%) мянган автомашинаар нэмэгджээ.



Хүснэгт 1. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины тоо, 2014-2018 он

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	Үүнээс: автомашины төрөл			
						Автобус	Ачаа	Суудал	Тусгай зориулалт
Нийслэл	297 008	331 564	339 626	365 819	401725	10301	75256	309812	6356
Сүхбаатар	39 780	47 746	46 906	54 341	55490	1554	10668	42094	1174
Нийслэлийн дүнд эзлэх %	13.4	14.4	13.8	14.9	13.8	15.1	14.2	13.6	18.5
Амины автомашин									
Нийслэл	238 183	265 352	275 084	294 472	326290	5 462	52458	266697	1673
Сүхбаатар	25 686	30 711	30 962	31 274	32050	506	4710	26 703	131
Нийслэлийн дүнд эзлэх %	10.8	11.6	11.3	10.6	9.8	9.3	9.0	10.0	7.8

Зураг 2. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины тоо, 2014-2018 он




Дүүргийн үзлэгт хамрагдсан автомашины тоо 2014 оноос 1.0 пунктээр, 2015 оноос 1.8 пунктээр, 2016 оноос 1.5 пунктээр, 2017 оноос 0.8 пунктээр тус тус буурчээ.

2018 онд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан дүүргийн нийт автомашиныг төрлөөр нь авч үзвэл дийлэнх буюу 75.9 хувийг суудлын, 19.2 хувийг ачааны, 2.8 хувийг автобус, 2.1 хувийг тусгай зориулалтын автомашин эзэлж байна.

Дүүргийн үзлэгт хамрагдсан автомашины 57.8 хувь нь амины автомашин бөгөөд нийслэлийн дүнд эзлэх хувь 9.8 байна.


Зураг 3. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашин төрлөөр, 2014-2018 он



Хүснэгт 2. Автомашины тоо, өмчлөлийн хэлбэрээр, 2014-2018 он

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Төрийн болон орон нутгийн өмчийн	720	711	746	768	758
Дипломат, олон улсын байгууллагын	313	312	351	36	357
Төрийн бус байгууллагын	606	631	543	685	824
Компани, хоршоо, нөхөрлөлийн	12455	15381	14304	21248	21501
Амины авто машин	25686	30711	30962	31274	32050
Нийт авто машин	39780	47746	46906	54341	55490

Зураг 4. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины тоо, өмчлөлийн хэлбэрээр, 2018 он



2018 онд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан дүүргийн нийт автомашины 1.4 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн, 0.6 хувийг дипломат болон олон улсын байгууллагын, 1.5 хувийг төрийн бус байгууллагын, 38.7 хувийг компани, хоршоо, нөхөрлөлийн, 57.8 хувийг амины авто машин эзэлж байна.

Хүснэгт 3. Амины автомашин, төрлөөр, 2014-2018 он

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Суудлын автомашин	20 840	25 591	25 955	26 133	26 703
Ачааны автомашин	3 948	4 291	4 374	4 512	4 710
Автобус	653	701	499	504	506
Тусгай зориулалтын автомашин	245	128	134	125	131
Нийт	25 686	30 711	30 962	31 274	32 050

Амины автомашины 83.3 хувийг суудлын, 14.7 хувийг ачааны, 1.6 хувийг автобус 0.4 хувийг тусгай зориулалтын авто машин эзэлж байна.

Хүснэгт 4. Автомашины тоо, ашиглалтын хугацаагаар, 2014-2018 он

		2014	2015	2016	2017	2018
Үүнээс:	Нийслэл /жилээр/	297 008	331 564	339 626	365 819	401725
	0-3	16 686	12 306	9 104	8 706	10296
	4-9	69 883	78 560	74 891	82 861	94257
	10-с дээш	210 439	240 698	255 631	274 252	297172
Үүнээс:	Дүүрэг /жилээр/	39 780	47 746	46 906	54 341	55490
	0-3	3 780	2 804	2 213	2 492	2827
	4-9	10 252	13 090	12 035	14 274	14472
	10-аас дээш	25 748	31 852	32 658	37 575	38191

2018 оны байдлаар нийслэл хотын үзлэгт хамрагдсан нийт автомашины 74.0 хувийг 10-с дээш жил ашигласан тээврийн хэрэгсэл эзэлж байна. Үүний 12.9 хувь нь Сүхбаатар дүүрэгт байна.

Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан дүүргийн нийт автомашины 5.1 хувийг 0-3 жил ашигласан, 26.1 хувийг 4-9 жил ашигласан, дийлэнх буюу 68.8 хувийг 10-аас дээш жил ашигласан автомашин эзэлж байна.



ИНФОГРАФИК МЭДЭЭЛЭЛ



**ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ
ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ**

Статистик-2018



ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН НИЙТ АВТО МАШИНЫ ТОО, төрлөөр



ӨМЧЛӨЛИЙН ХЭЛБЭРЭЭР



АШИГЛАЛТЫН ХУГАЦААГААР



“Иргэдийн оролцоотой” “Хөгжлийн жил”

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

Эх сурвалж: Авто тээврийн үндэсний төв, ТӨҮГ-ын мэдээлэл
Танилцуулга бэлтгэсэн: Мэргэжилтэн Б.Хандмаа

ЗДТГ, 204 тоот
Утас: 7010-7098
Имайл: Sukhbaatar_dist@nso.mn
Веб: www.ubstat.mn

Governor's office8 Room-204
Phone: 7010-7098

E-mail: Sukhbaatar_dist@nso.mn
Web: www.ubstat.mn